УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/116/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

20 | УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1. Аудитын санал дүгнэлт....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
3. Аудитын тайлан ....12
3.1 Ерөнхий зүйл ....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4 Материаллаг байдал....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....14
3.8 Аудитын гол асуудал....15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
4. Аудитын илрүүлэлт....16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/116/ИА-СТА-ТИ43
танай ________-ны №________-т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БУЯНТОГТОХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200367

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **75,432,624.88** | **74,965,641.60** |
| **33** | **АВЛАГА** | 40,288.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 40,288.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 75,392,336.88 | 74,965,641.60 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,662,473.00 | 11,662,473.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,662,473.00 | 11,662,473.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 63,729,863.88 | 63,303,168.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,067,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 973,650.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 61,689,213.88 | 63,303,168.60 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,423,897,446.83** | **2,324,324,335.62** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,423,897,446.83 | 2,324,324,335.62 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,063,734,113.55 | 1,963,191,835.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,505,862,539.37 | 2,458,654,588.37 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -585,906,133.62 | -630,858,265.50 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 13,000,000.00 | 13,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -13,000,000.00 | -13,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 211,458,623.91 | 199,198,276.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -167,367,166.73 | -157,263,283.81 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 127,710,489.36 | 112,815,655.63 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -54,865,120.18 | -49,270,853.54 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,001,700.00 | 5,001,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,976,700.00 | -3,426,700.00 |
| 39217 | Ном | 24,815,881.44 | 28,340,717.84 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 360,163,333.28 | 361,132,499.89 |
| 39301 | Програм хангамж | 3,654,860.00 | 5,504,860.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,091,526.72 | -2,972,360.11 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 358,600,000.00 | 358,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,499,330,071.71** | **2,399,289,977.22** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,499,330,071.71** | **2,399,289,977.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,499,330,071.71 | 2,399,289,977.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,171,009,490.33 | 1,171,009,490.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,171,009,490.33 | 1,171,009,490.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -323,597,927.20 | 576,361,978.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -323,597,927.20 | -323,597,927.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 899,959,905.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 651,918,508.58 | 651,918,508.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,499,330,071.71** | **2,399,289,977.22** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,510,418,994.48** | **2,421,581,655.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,472,938,994.48** | **2,392,792,864.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 42,630,144.48 | 978,992,940.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 42,630,144.48 | 978,992,940.12 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 42,630,144.48 | 978,992,940.12 |
| **122** | **Тусламжийн орлого** | 179,119,450.00 | 230,077,924.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,251,189,400.00 | 1,183,722,000.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,251,189,400.00 | 1,183,722,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **37,480,000.00** | **28,788,791.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 37,480,000.00 | 28,788,791.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,880,000.00 | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 8,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 788,791.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,522,123,207.39** | **1,517,619,576.04** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,522,123,207.39** | **1,517,619,576.04** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,452,174,910.39 | 1,468,418,137.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,015,329,927.00 | 988,928,250.00 |
| 210101 | Үндсэн цалин | 661,126,946.31 | 653,322,250.00 |
| 210102 | Нэмэгдэл | 270,729,000.00 | 270,729,000.00 |
| 210104 | Урамшуулал | 83,473,980.69 | 64,877,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 129,054,700.00 | 128,629,319.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,757,200.00 | 89,175,419.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,324,400.00 | 9,863,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,259,500.00 | 7,890,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,064,800.00 | 1,972,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,648,800.00 | 19,726,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 173,648,892.00 | 224,727,924.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,130,499.00 | 2,377,301.00 |
| 210302 | Түлш, халаалт | 167,495,400.00 | 219,279,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,022,993.00 | 3,071,423.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,487,647.80 | 20,317,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,778,500.00 | 932,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 734,100.00 | 2,541,130.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 677,300.00 | 1,081,440.00 |

20 ... ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 6,000.00 | 71,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,989,450.00 | 3,028,890.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,137,400.00 | 2,724,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 19,164,897.80 | 9,938,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,696,400.00 | 1,506,670.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 344,400.00 | 341,170.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,352,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,165,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,350,000.00 | 15,695,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,350,000.00 | 15,695,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 135,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 135,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,853,000.00 | 2,858,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 1,130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,400.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 550,000.00 | 812,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 131,600.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,754,343.59 | 85,619,414.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,882,800.00 | 10,076,591.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 89,871,543.59 | 75,542,823.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 69,948,297.00 | 49,201,439.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,144,100.00 | 44,933,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,531,600.00 | 42,223,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,612,500.00 | 2,710,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 4,268,239.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 120,558.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,683,639.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,683,639.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,704,212.91** | **903,962,079.08** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 4,002,173.57 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 4,002,173.57 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -4,002,173.57 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-11,704,212.91** | **899,959,905.51** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,467,788,850.00** | **1,442,588,715.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,430,308,850.00** | **1,413,799,924.00** |
| **122** | **Тусламжийн орлого** | 179,119,450.00 | 230,077,924.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,251,189,400.00 | 1,183,722,000.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,251,189,400.00 | 1,183,722,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **37,480,000.00** | **28,788,791.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 37,480,000.00 | 28,788,791.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,880,000.00 | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 8,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 788,791.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,432,908,850.00** | **1,442,588,715.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,432,908,850.00** | **1,442,588,715.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,362,960,553.00** | **1,393,387,276.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,015,192,261.00 | 988,887,962.00 |
| 210101 | Үндсэн цалин | 660,989,280.31 | 653,281,962.00 |
| 210102 | Нэмэгдэл | 270,729,000.00 | 270,729,000.00 |
| 210104 | Урамшуулал | 83,473,980.69 | 64,877,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 129,054,700.00 | 128,629,319.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,757,200.00 | 89,175,419.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,324,400.00 | 9,863,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,259,500.00 | 7,890,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,064,800.00 | 1,972,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,648,800.00 | 19,726,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 173,648,892.00 | 224,727,924.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,130,499.00 | 2,377,301.00 |
| 210302 | Түлш, халаалт | 167,495,400.00 | 219,279,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,022,993.00 | 3,071,423.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,051,500.00 | 13,281,910.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,770,000.00 | 722,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 734,100.00 | 2,541,130.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 677,300.00 | 1,075,440.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 655,600.00 | 655,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,790,100.00 | 2,599,740.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,424,400.00 | 5,688,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 3,861,900.00 | 1,506,670.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 344,400.00 | 341,170.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,352,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,165,500.00 | 1,165,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,350,000.00 | 22,320,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 5,880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,350,000.00 | 16,440,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 135,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 135,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,853,000.00 | 4,708,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 1,130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,400.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 550,000.00 | 2,662,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 131,600.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,948,300.00 | 9,189,591.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,948,300.00 | 9,189,591.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **69,948,297.00** | **49,201,439.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,144,100.00 | 44,933,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,531,600.00 | 42,223,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,612,500.00 | 2,710,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 4,268,239.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 4,268,239.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 120,558.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 120,558.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,683,639.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,683,639.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **34,880,000.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **34,880,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **34,880,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 34,880,000.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 34,880,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-34,880,000.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 812,409,490.33 | 00.00 | 189,048,352.89 | 1,001,457,843.22 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -00.13 | -00.13 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **812,409,490.33** | **00.00** | **189,048,352.76** | 1,001,457,843.09 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 358,600,000.00 | 00.00 | -77,698,357.19 | 280,901,642.81 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,171,009,490.33** | **651,918,508.58** | **-323,597,927.20** | 1,499,330,071.71 |
| **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **1,171,009,490.33** | **651,918,508.58** | **-323,597,927.20** | 1,499,330,071.71 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,171,009,490.33** | **651,918,508.58** | **-323,597,927.20** | 1,499,330,071.71 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 899,959,905.51 | 899,959,905.51 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,171,009,490.33** | **651,918,508.58** | **576,361,978.31** | 2,399,289,977.22 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,415,840,400.00 | 1,409,531,685.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,415,840,400.00 | 1,409,531,685.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,371,153,500.00 | 1,365,698,485.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 989,848,100.00 | 988,887,962.00 |
| 210101 | Үндсэн цалин | 654,242,100.00 | 653,281,962.00 |
| 210102 | Нэмэгдэл | 270,729,000.00 | 270,729,000.00 |
| 210104 | Урамшуулал | 64,877,000.00 | 64,877,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 129,657,000.00 | 128,629,319.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,203,100.00 | 89,175,419.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,863,500.00 | 9,863,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,890,800.00 | 7,890,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,972,700.00 | 1,972,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,726,900.00 | 19,726,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 226,768,400.00 | 224,727,924.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,000,000.00 | 2,377,301.00 |
| 210302 | Түлш, халаалт | 219,279,200.00 | 219,279,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,489,200.00 | 3,071,423.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,957,000.00 | 8,951,910.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 722,000.00 | 722,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,734,100.00 | 1,731,130.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 677,300.00 | 675,440.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 655,600.00 | 655,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,300,000.00 | 2,299,740.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,868,000.00 | 2,868,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,509,900.00 | 1,506,670.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 344,400.00 | 341,170.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,165,500.00 | 1,165,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,350,000.00 | 5,350,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,350,000.00 | 5,350,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,470,900.00 | 135,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,470,900.00 | 135,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,671,400.00 | 2,588,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,150,000.00 | 1,130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 165,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 550,000.00 | 542,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4920800.00 | 4920800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,920,800.00 | 4,920,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44686900.00 | 43833200.00 |

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,686,900.00 | 43,833,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,074,400.00 | 42,223,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,612,500.00 | 1,610,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,415,840,400.00 | 1,409,531,685.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,183,722,000.00 | 1,179,453,761.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,183,722,000.00 | 1,179,453,761.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 232,118,400.00 | 230,077,924.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 232,118,400.00 | 230,077,924.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 78.00 | 78.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 70.00 | 70.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.00 | 07.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **28,788,791.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **28,788,791.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 27,688,791.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,330,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 810,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 400,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,820,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,970,000.00 |
| 210602 | Тавилга | 5,880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,090,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,120,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,120,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4268791.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,268,791.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1100000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 28788791.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,788,791.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 788,791.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3 . Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь бүх нийтийн ерөнхий боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 6,088.5 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,517,619.6 төгрөгийн 0.5 хувь буюу 7,588.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,070.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 899,959.9 мянган төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 40.3 | | -40.3 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 75,392.3 | 74,965.6 | -426.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,423,897.5 | 2,324,324.4 | 900,426.9 |
| **Нийт хөрөнгө** | 1,499,330.1 | 2,399,290 | 899,959.9 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,499,330.1 | 2,399,290 | 899,959.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,499,330.1 | 2,399,290 | 899,959.9 |

Бараа материалын дансны үлдэгдэл 74,965.6 мянган төгрөг болж 426.7 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталж устгаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,324,324.4 мянган төгрөг болж 900,426.9 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан өргөтгөлийн барилга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөл бөмбөгийн талбай нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 8,308.3 мянган

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 971,663.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Акталж устгасан 48,960.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 911,162.7 мянган төгрөгөөр буюу 60.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,503.6 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,759,548.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,759,548.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 343,708.0 мянган төгрөгөөр бууруулж 1,415,840.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,415,840.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,183,722.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 232,118.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,179,453.8 мянга, орон нутгийн төсвөөс 230,077.9 төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,409,531.7 мянган төгрөгийг зарцуулж 4,268.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,409,531.7 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь зардлыг 4,268.2 мянган төгрөгөөр хэмнэж орон нутгийн төсвөөс 2,040.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 8,000.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 788.8 мянга, нийт 28,788.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ